



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

111

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

┌ Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ┐

Монгол Улсын Засгийн газрын тухай 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Журам батлах тухай” Гадаад харилцааны сайдын 2020 оны А/34 тушаалын хавсралтаар баталсан “Гадаадад зорчиж байгаа албаны хүмүүсийг угтах, үдэх журам”-д дор дурдсан агуулгатай 9 дэх заалтыг нэмсүгэй:

“9. ТӨ-II зэрэглэлд (Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд) хамаарах албан тушаал хашиж байсан хүмүүс, тэдгээрийн эхнэр, нөхөр гадаад улсад зорчиход тухайн улсад суугаа ДТГ-ын дэд тэргүүн эсхүл дипломат ажилтан нисэх онгоцны буудалд угтаж, үднэ.”

2. Мөн журмын 9 дэх заалтын “8” гэсний дараа “, 9” гэж нэмсүгэй.

3. Мөн журмын 8 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүмүүс, тэдгээрийн эхнэр, нөхөр гадаад улсад зорчиход тухайн улсад суугаа ДТГ-ын тэргүүн нисэх онгоцны буудалд угтаж, үдэж, байх хугацаанд нь унаагаар үйлчилнэ.”

4. Мөн журмын 9, 10 дахь заалтын дугаарыг “10, 11” гэж тус тус өөрчилсүгэй.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

Гадаад, харилцааны төв архив

101220205